


 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# **“САВ, БАГЛАА БООДОЛ”** **үндэсний хөтөлбөрийн тухай**

*ХҮБХЗГ-ын дарга Т.Гантогтох*

Улаанбаатар хот  
2017.11.21

 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## **АГУУЛГА**

- Хөтөлбөрийн тухай товч;
- Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага;
- Хөтөлбөрийн зорилт;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим;
- Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт;
- Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт;
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ.

---



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## “САВ, БАГЛАА БООДОЛ” үндэсний хөтөлбөр

Засгийн газрын 2016 оны  
287 дугаар тогтоол

### □ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх хууль, эрх зүйн болон бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээг бууруулахад оршино.

□ 3 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг хэрэгжүүлнэ.

□ ХЭРЭГЖИХ ХУГАЦАА: 2017-2021



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

□ Улаанбаатар хот: 297 өрх.

-Хуванцар сав хэрэглэдэг 90%.

-Хүнсний зориулалтын бус, 20-100 л багтаамжтай 3-4 ш сав.

-Хуванцар савны олон улсын ангиллын тэмдэглэгээ, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдлэг дутмаг 78%.

*/Хордлого судлал, эрдэм шинжилгээний нийгэмлэг, 2015/*

□ Хуванцар саванд хадгалсан усан дахь хар тугалгын шилжилтийн хэмжээ ДЭМБ-ын зөвлөмж хэмжээ болон Монгол Улсад мөрдөж байгаа стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 60-800, формальдегид 1800-6900 дахин их байна.

*/Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн/*



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## ҮРГЭЛЖЛЭЛ

□“Нарантуул” худалдааны төвд зарагдаж байгаа зориулалтын бус хуванцар саванд хонуулсан усны дээжинд хийсэн химийн бодис, хүнд металлын үлдэгдэл тодорхойлох шинжилгээгээр аммиакийн агууламж төвлөрсөн сүлжээний усан дахь агууламжаас 48, төмөр 2, нитрит 11 дахин тус тус их гарсан бөгөөд хадгалах хугацаа нэмэгдэх тусам химийн бодисын шилжилт нэмэгдэж байна.

*/МХЕГ/*

□Монгол Улс жилдээ 330 гаруй тэрбум төгрөгийн сав, баглаа боодлын бүтээгдэхүүн хэрэглэдгээс 30 орчим хувь буюу 70 тэрбум төгрөгийн сав, баглаа боодлын бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж байна.

*/Сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн холбоо/*



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

□“ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”  
*/УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоол/*

4.1.10-т “хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх үе шатанд хэрэглэх, дэвшилтэт технологийг нутагшуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжинэ”.

□“НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО”  
*/УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол/*


3.1.6-д “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгож, байгальд халгүйгээр хадгалах, савлах технологийг дэмжинэ”.


**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

## ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ


1. Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ээлтэй сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжсэн хууль, эрх зүйн болон бизнесийн таатай орчныг бүрдүүлэх;
2. **Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах;**
3. Сав, баглаа боодлын үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх.




**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

## ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- хувийн хэвшлийн бүтээлч санал, санаачилгыг төрөөс дэмжих;
- импортын бүтээгдэхүүнийг орлох үндэсний үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжих;
- хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах;
- цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- иргэн, гэр бүл, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн идэвхтэй оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлах.


**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

## ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

➤ Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохицуулах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах **Үндэсний зөвлөл:**  
*/ХХААХУ-ийн сайдын 2017 оны А/54 дүгээр тушаал/*

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба;  
 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;  
 Эрүүл мэндийн яам;  
 Байгаль орчин, аялал жуулчлалын яам;  
 Сангийн яам;  
 Мэргэжлийн хяналтын ерөнхий газар;  
 Стандарт, хэмжил зүйн газар;  
 Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар;  
 Нийслэлийн Засаг даргын Тамгын газар;  
 Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв;  
 Шинжлэх ухаан, технологийн их сургууль;  
 Монголын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо;  
 “Заша өвс” төрийн бус байгууллага.


**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Хүрэх үзүүлэлт	Өөрчлөлт /%
1	Нэг өрхийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хадгалдаг зориулалтын бус хуванцар савны тоо	ширхэг	3-4	1-2	-50
2	Хуванцар савны олон улсын ангиллын тэмдэглэгээ, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдлэг бүхий хэрэглэгч	хувь	22	50	+28
3	Сав, баглаа боодол, хаяг шошгын дотоодын үйлдвэрлэлийн зах зээлд эзлэх хувь	хувь	30.0	50.0	+20
4	Хүнд даацын уутны дотоодын үйлдвэрлэлийн зах зээлд эзлэх хувь	хувь	60	100	+40



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3.1.3. хүнсний зориулалтын бус саван дээр **анхааруулах тэмдэглэгээ** тавьдаг болох эрх зүйн зохицуулалт бий болгох;

3.1.4. сав, баглаа боодол, хаяг шошгын үйлдвэрлэл, импорт, худалдаа, хэрэглээг хамарсан техникийн зохицуулалт гаргах, олон улсын стандартуудыг нутагшуулах, одоо мөрдөж байгаа стандартуудыг шинэчлэх;

3.1.6. сав, баглаа, боодлын аюулгүй байдлыг хангах, хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд **дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламжийн** хөрөнгийг уг салбарт зарцуулахыг дэмжих.



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## ҮРГЭЛЖЛЭЛ

3.2.2. Сав, баглаа боодлын аюулгүй байдлыг хангах, хаяг шошгын бичлэг үнэн зөв эсэхийг баталгаажуулдаг болох, үйлдвэрийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр түншлэгч орнууд, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлж, олон улсын сайн туршлагыг нутагшуулах;

3.2.7. Хүнсний сав, баглаа, боодлын худалдаа, хэрэглээний талаар хэрэглэгчдэд чиглэсэн зөвлөмж, зөвлөгөө, мэдээ мэдээлэл болон сэрэмжлүүлгийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх, сурталчлах;

3.2.16. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн зөөвөрлөх, хадгалахад ашиглаж байгаа зориулалтын бус савыг зориулалтын саваар солих арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## ҮРГЭЛЖЛЭЛ

3.2.5. түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодлын уян хатан, бат бөх чанар, найрлагыг судлах, тэмдэглэгээг баталгаажуулах, чанар, эрүүл ахуйн үнэлгээ хийх лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авах;

3.2.6. хүнсний зориулалтын сав, баглаа боодлын лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэн, ажилтнуудыг чадавхжуулах зэрэг арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;

3.2.15. хүнсний чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан сав, баглаа боодлын эрүүл ахуй, чанар стандарт, аюулгүй байдлын талаар тусгайлан сургалт зохион байгуулах г.м

---



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## ҮРГЭЛЖЛЭЛ

3.3.1. хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй, шинэ технологи бүхий сав, баглаа боодлын эко үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжих;

3.3.2. уламжлалт модон торх, ган, хувин, ширэн хөхүүр, гоёл чимэглэлийн уут, савны урлалыг дэмжиж брэнд болгох ажлыг орон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулах, даавуун болон цаасан тор, уутны хэрэглээг дэмжих;

3.3.6. Олон улсын сав, баглаа боодлын холбоонд гишүүнээр элсэх боломжийг судалж шийдвэрлэх...

---



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

**АНХААРАЛ ТАВЬСАНД  
БАЯРЛАЛАА.**

[gantogtokh@mofa.gov.mn](mailto:gantogtokh@mofa.gov.mn)